

СУДЛАГДАХУУНЫ НЭР: МЭДЭЭЛЭЛ ЗҮЙ

ИЛТГЭЛИЙН НЭР: “Мэдээлэл хаана
хадгалагдах вэ?” судалгаат хичээлийн арга
зүйн туршлага

ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

- ▣ **Яагаад энэхүү судалгаат хичээлийг зохион байгуулах болсон тухай**
- ▣ Jica мониторингийн баг 2013 оны 09 сарын 24-25-нд манай сургууль дээр ирж ажилласан. 4 судлагдахууны хичээл заахаар байсны нэг нь мэдээлэл зүйн хичээл юм. Ингээд 7-р ангийн Мэдээлэл зүйн хичээлийн Мэдээлэл бүлэг сэдвийн “Мэдээлэл хаана хадгалагдах вэ?” сэдвийг сонгож судалгаа хийсэн. Энэ сэдвийг сонгосон учир нь манай сургуульд 5-р ангид нь мэдээлэл зүйн хичээл ордоггүй, мэдээлэл зүйн багш нэг байдаг өөр мэргэжлийн багш нартай хамтран бэлтгэл судалгаа хийх тул сонгосон.

▣ **Хичээлийн санааг хэрхэн яаж олсон болох, хичээлийн гол санаа юу болох**

Хичээлийн гол санаа нь мэдээлэл бидний эргэн тойронд хаана хаана хадгалагддаг тухай, тэгвэл компьютерт мэдээллийг яаж хадгалах вэ гэдгийг ойлгуулах. Байгаль дээрх зарим зүйл мэдээлэл хадгалж байдаг мөн хүн мэдээллийг хадгалах зүйл хийсэн байдаг бөгөөд өвөө эмээгийн үед , аав ээжийн үед, орчин үед мэдээллийг хаана хадгалж байгааг яриулаж хичээлээ явуулах санаа дэвшигдэж байсан.

Хичээлийн бэлтгэл судалгааг хэнтэй, хэрхэн яаж хийсэн тухай

- ▣ Сургууль дээр байгуулагдсан мэдээлэл зүйн судлагдахууны багтай хамтран бэлтгэл судалгааг 7 хоног үдээс хойш 15-19 цагийн хооронд хийж байсан.

Хэзээ хэдэн удаа заасан тухай

- ▣ 2013 оны 09 сарын 25-ны өглөө 09 цагт судалгаат хичээлийг 1 удаа заасан

Хэрхэн сайжруулсан, юуг, яаж сайжруулсан тухай

- ▣ Өвөө, эмээгийн, аав ээжийн үе гэдгээ тодруулан он бичиж өгөх. Сурагчдын дэвтэрт үлдэх зүйл дээр анхаарч төлөвлөж ажиллах

ХИЧЭЭЛИЙН ЭХЛЭЛ ХЭСГИЙН ШИЙДЭЛ

Сэдэлжүүлэх шийдэл

Байгаль дээр хадгалагдаж байдаг мэдээллээр сэдэлжүүлье гэсэн санаа дэвшигдэн модны тайрдасаар сэдэлжүүлэхээр болсон. 3 баг тус бүрт нэг нэг модны тайрдас өгч үүнээс ямар мэдээлэл авч болохыг яриулах. Сурагчид өөрсдийн харж, мэдэрсэнээрээ хариулт өгнө. мод зомголтой , дугуй цагираг, жижиг байна... гэх мэтээр хариулна Цагирагийн тоогоор модны насыг тодорхойлж болдог.Цагираг нимгэн зузаанаас шалтгаалан тухайн жилийн мэдээлэлийг авч болно.\мод өөрийн тухай мэдээллийг хадгалж байна\.

Сэдэлжүүлэлтийг 4 минут үргэлжилэхээр тооцсон хугацаа тохирсон.

Хичээлийн зорилгоо хэрхэн таниулж ойлгуулсан болох

Мэдээллийг хаана хадгалддаг, мэдээллийг тээгч гэж юу болох , компьютерт мэдээллийг яаж хадгалдаг вэ гэсэн ойлголтыг сурагчдад эзэмшүүлэх зорилготой хичээл байсан. Сэдэлжүүлэх, сэргээн сануулах үе дээр мэдээллийг дүрслэх хэлбэрийг \хад-гал- г-дах\ зураг бичвэрээр өгөөд бичгэн мэдээлэл болгон уншаарай гэдгээс хичээлийн сэдэв зорилгоо танилцуулсан.

ХИЧЭЭЛИЙН ӨРНӨЛ ХЭСГИЙН ШИЙДЭЛ

Хүүхдээр юуг яаж нээлгэсэн тухай алхамууд

- ▣ 1-р баг: өвөө эмээгийн үед мэдээллийг хаана хадгалдаг байсан бэ? Хариулт: ном сонин...
- ▣ 2-р баг: аав ээжийн үед мэдээлэл хаана хадгалдаг байсан бэ? Хариулт: ном, сонин, сэтгүүл, аудио, видео, хуурцаг, пянз...
- ▣ 3-р баг: одоо үед та нар мэдээллийг хаана хадгалдаг вэ? Хариулт: flash, memory, CD, DVD, сонин сэтгүүл, компьютер.....
- ▣ Өвөө, эмээгийн өмнөх үе: Эртний хүмүүс мэдээллийг хаана хадгалдаг байсан бэ? Хариулт: хад чулуу, муутуу цаас
- ▣ Багууд хамтран ярилцаж тухайн өгөгдсөн сэдвийн талаарх ойлголтоо нэгтгэн бичиж самбарт байрлуулах. Сурагчдын нэрлэсэн мэдээлэл тээгчүүдийг биетээр харуулан байрлуулах. Мэдээлэл тээгч гэсэн нэр томъёог гаргах. Эдгээр үе шатуудыг хараад мэдээлэл тээгчүүдийг харьцуулаад ялгааг хэлүүлэх. Ном сонин-ижил Хуурцаг, пянз-хэмжээгээрээ том, жижиг. Мэдээллийн төрөл агууламжаараа. Мэдээллийг хадгалах хамгийн түгээмэл хэлбэр нь flash, memory, CD, DVD, компьютер буюу цахим хэлбэр юм. Байгаль дээрх бүх зүйл тодорхой өөрсдийн гэсэн мэдээллийг хадгалж байдаг. Компьютерт мэдээллийг яаж хадгалах вэ? Гэдгээс зураг зурдаг хялбар программ ашиглан дүрс зуруулах. Сурагчид ихэвчлэн зурж чадаж байсан. Багш зурсан зургийг хадгалах үйлийн дарааллыг зааж сурагчид даган хийж байсан. Зарим сурагчид өөрсдөө хадгалж чадаж байсан.

ХИЧЭЭЛИЙН ТӨГСГӨЛ ХЭСГИЙН ШИЙДЭЛ

Нэгтгэн дүгнэх

- ▣ Үзсэн зүйлээ товч тэмдэглэх. Дорж надад утасны дугаараа хэлээч багш нь тогтоогоод авчихлаа. Утасны дугаар хаана хадгалагдсан бэ? Хариулт: Тархинд, Мэдээллийг хадгалахад зориулагдсан тусгай байгууллагууд байдаг. түүнийг та нар нэрлэнэ үү? Гэж асуудал дэвшүүлэн олж авсан мэдлэгийг баяжуулах. Мэдээллийг хадгалахын тулд компьютерийн ямар байгууламжуудыг ашигладаг вэ? Асуудлаар нэгтгэн ярилцана. Энэ дүгнэлт нь салангад олон асуудал болсон сайжруулахдаа мэдээлэл хаана хаана хадгалагддагыг баг бүрээр нэгтгэн ярилцуулж нэгдсэн нэг дүгнэлт гаргах.

Бататгах

- ▣ Мэдлэг бүтээх үед орчин үед мэдээллийг хадгалдаг төхөөрөмжүүдийг мэдэж хэлсний дараа компьютерт мэдээлэл хадгалдаг гэсэн хариултын үндсэн дээр одоо компьютерт хийсэн зүйлээ яаж хадгалдаг болохыг үзье. Зураг зурах хялбар программ paint дээр нар зуръя. Зурсан зургаа багшийг даган хийж хадгалах. Энэ мэдээлэл хаана хадгалагдсан бэ? -компьютер дээр мэдээлэл нь шуурхай санах ой-RAM –д, Хатуу диск-д хадгалагддаг гэдгийг багш хэлэх. Сурагчид харьцангуй идэвхитэй сайн оролцож байсан. Сайжруулахад анхаарах санал багш өөрөө зурсан зургийг нь хадгалах үйлдлийг заах биш хадгалж чаддаг сурагч байна уу? Гэж асууж байгаад чадаж байгаа сурагчаар бусдад нь заалгах.

Гэрийн даалгавар

ДҮГНЭЛТ

Өмнөх сэдэв болон математикийн хичээлтэй холбож өгсөн. 3 үеийн мэдээллийг хадгалдаг түүхийг сөхсөн нь сайн байсан. Компьютерийн командууд англи хэлээр байдаг учраас англи хэлтэй холбох. Мэдээллийг хаана хадгалах гэсэн санааг агуулгаа болгон авах, яаж хадгалахыг нь дараагийн хичээл болгон оруулах. Мэдээлэл зүйн хичээл нь ихэвчлэн сурагчдын дэвтэрт тэмдэглэгээ үлдэхгүй байх магадлал их байдаг үүн дээр анхаарах. Хадгалах командын гарын хослолыг давхар хэлж өгвөл зүгээр болов уу. Тухайн мэдээлэл тээгч ямар хэмжээний мэдээлэл хадгалж болохыг харуулж өгвөл сонирхолтой болох байлаа. Энэ судалгаат хичээлийг заахад сурагчдын өмнөх төсөөллийг сайн судлах хэрэгтэй. Судалгаат хичээлийн бэлтгэл судалгааг хийн зааж ажиглан хэлэлцүүлэг зохион байгуулсан сайжруулах саналаас дүгнэв. “Мэдээлэл хаана хадгалагдах вэ” судалгаат хичээлийн арга зүйн туршлагаа түгээж байна та бүхэн өөрсдийн арга зүйдээ тулгуурлан сайжруулан зааж туршиж үзэхийг хүсэж байна.

НОМ ЗҮЙ

- ▣ Мэдээлэл зүйн судлагдахууны зөвлөмж -1, 2, 3
- ▣ Мэдээлэл зүйн модуль
- ▣ Мэдээлэл зүйн хичээлийн стандарт

Анхаарал хандуулсанд баярлалаа